



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 05 өдөр

Дотоо А/65

Улданбаатар жог

Чиглэл батлах тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалтыг үндэслэн, Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний 3.2.1 дэх зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. "Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангид хүүхдээ 6 настайд нь элсүүлэх боломжгүй малчин иргэний хүсэлтийг шийдвэрлэхэд баримтлах чиглэл"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд 6 настай хүүхэд амьдрах орчин, нөхцөл, үйлчилгээг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч ажиллахыг Аймгийн Засаг дарга нарт зөвлөсүгэй.

2.1 Дотуур байрыг шинээр барих, өргөтгөх, дотуур байрын орчин нөхцөл, үйлчилгээг сайжруулах ажлыг үе шаттай төлөвлөн хэрэгжүүлэх;

2.2 Дотуур байранд 6 настай хүүхдэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх туслах багш ажиллуулах орон тоо, төсвийг батлагдсан орон тоо, төсөвтөө багтаан шийдвэрлэн, хэрэгжүүлэх.

3. Чиглэл хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч ажиллахыг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга нарт даалгасугай.

3.1 Хүүхдийн 6, 7, 8 настай хүүхдийн хөгжлийн онцлог, ялгаа, нас хэтэрч сургуульд элссэний улмаас хүүхдийн хөгжил төлөвшилд үзүүлэх сөрөг нөлөөний талаар эцэг эх, асран хамгаалагчдыг мэдээллээр хангах, мэргэжлийн зөвлөгөө өгөх;

3.2 Дотуур байранд 6 настай хүүхэд амьдрах орчин, үйлчилгээний нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авч, иргэн, олон нийтэд нээлттэй танилцуулах, мэдээлэл өгөх олон талт үйл ажиллагааг зохион байгуулах;

3.3 Зургаан настай хүүхдийн эцэг, эх тодорхой хугацааны давтамжтайгаар хүүхэдтэйгээ уулзаж байх талаар тэдэнтэй зөвшилцөн, гэрээ байгуулах, дотуур байранд уулзалтын ерөө байгуулах арга хэмжээ авч ажиллахыг ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад даалгах;

3.4 Малчдын 5 настай хүүхдийг сургуульд бэлтгэх, тэднийг сургуулийн орчинтой танилцуулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран үе шаттай зохион байгуулах.

4. Тушаалын хэрэгжилтийг арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /М.Мөнхбаатар/-д даалгасугай.

5. Чиглэлийн дагуу ажилласан тухай тайланг сургууль жил бүрийн 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор аймгийн Боловсрол, соёл, урлагийн газарт, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар сургуулиудын тайланг нэгтгэж, холбогдох санал, дүгнэлтийн хамт Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Бодлогын хэрэгжилтийн зохицуулах газарт 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор, аймгуудын тайланд дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний саналын хамт 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор сайдад танилцуулахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга /З.Энхболд/-д үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалын хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар ханган, хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Б.Баярсайхан/-д даалгасугай.

САЙД

The image shows a rectangular official stamp with a decorative border. Inside the stamp, there is a large, stylized signature in cursive script. To the left of the signature, there is vertical text in Mongolian. To the right, there is a date stamp: "2014.08.20". The stamp is placed over the name of the State Minister.

Г.ЧУЛУУНБААТАР

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын
сайдын 2017 оны 17 дугаар сарын 5-ний
өдрийн 17 дугаар тушаалын хэвсрэлт

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН НЭГДҮГЭЭР АНГИД ХҮҮХДЭЭ
6 НАСТАЙД НЬ ЭЛСҮҮЛЭХ БОЛОМЖГҮЙ МАЛЧИН ИРГЭНИЙ
ХҮСЭЛТИЙГ ШИЙДВЭРЛЭХЭД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ**

Нэг. Ерөнхий зүйл



1.1. Боловсролын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4.9 дэх заалтын хүүхдийг сургуульд элсүүлэх эсэхтэй холбогдох харилцааг зохицуулахад сургуулийн зөвлөлийг мэргэжлийн удирдамжаар хангах, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд энэхүү чиглэлийг баримтална.

1.2. Сургуулийн зөвлөл нь энэхүү журмын 1.1.-д хамаарах малчин иргэний хүсэлтийг шийдвэрлэхэд Боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

1.3. Энэхүү чиглэл нь сум, тосгон, багийн төвд сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа ерөнхий боловсролын сургууль болон хүсэлт гаргагч малчин иргэнд тус тус хамаарна.

1.4. Иргэн хүсэлтийг бичгээр гаргана.

1.5. Сургууль бүр энэхүү чиглэлийг хэрэгжүүлэхтэй холбогдох арга хэмжээг тухайн хичээлийн жилийн сургалт, хүмүүжлийн ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, үр дүнг тооцно.

1.6. Зайлшгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд сургуулийн зөвлөл малчин иргэний хүүхдийн сургуульд элсэх хугацааг нэг жилээр хойшлуулж болно. Энэ тохиолдолд хүүхэд 7 настайдаа нэгдүгээр ангид элсэн суралцана.

Хоёр. Хүсэлт шийдвэрлэхэд баримтлах зарчим

Сургуулийн зөвлөл, сургуулийн удирдлага нь малчин иргэний хүсэлтийг шийдвэрлэхэд дараах зарчим баримтална:

2.1. хүүхдийн сурч боловсрох эрхийг хүндэтгэх, тэдний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх;

2.2. хүсэлт гаргагчийн саналыг хүндэтгэх;

2.3. шийдвэр гаргахад сургуулийн зөвлөлийн гишүүдийн оролцоог тэгш хангах;

2.4. шийдвэр гаргах үйл ажиллагаа нь нээлттэй, ил тод, хараат бус байх;

2.5. шийдвэр нь холбогдох баримт нотолгоонд суурилсан байх;

2.6. шийдвэр нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хөгжил, төлөвшилд сөргөөр нөлөөлөхгүй байх;

Гурав. Хүсэлт шийдвэрлэх үйл ажиллагаа

3.1. Бага боловсролын сургалтын менежер малчин иргэний хүсэлт, холбогдох баримт бичгийг хүлээн авч, сургуулийн захиргаагаар уламжлан сургуулийн зөвлөлд танилцуулна.

3.2. Сургуулийн зөвлөл нь хүсэлт гаргасан иргэний хүсэлт, холбогдох баримт бичгийг жил бүрийн 5 дугаар сард багтаан судалж, хэлэлцэн шийдвэр /тогтоол/ гаргана. Хурлын шийдвэрт зөвлөлийн дарга, гишүүд гарын үсэг зурж, тухайн сургуулийн тамга тэмдгээр баталгаажуулна.

3.3. Сургуулийн зөвлөл нь хүсэлт гаргасан иргэний хүсэлтийг судлах явцад эцэг эхийг холбогдох мэдээллээр хангаж, харилцан зөвшилцсөний үндсэн дээр хүүхдийн сургуульд элсэх хугацааг нэг жилээр хойшлуулах эсэх талаар шийдвэр гаргана.

3.4. Сургуулийн захирал сургуулийн зөвлөлийн шийдвэрийг хүсэлт гаргагч иргэнд жил бүрийн 6 дугаар сарын эхний 7 хоногт багтаан албан бичгээр мэдэгдэнэ.

3.5. Сургуулийн зөвлөлийн шийдвэрээр сургуульд элсэх хугацааг нь хойшлуулсан хүүхдийг гэр бүлийн орчинд хөгжүүлэх, сургуульд бэлтгэх, сургуулийн орчинтой танилцуулах талаар сургууль, орон нутгийн удирдлага хамтран ажиллаж, эцэг эхэд дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна.